Алтайн баруун хязгаарт болсон байлдаан,
зэвсэгт мөргөлдөөний тухай

Би зохиолч, түүхч, судлаач, сэтгүүлч биш боловч 1964-1967 онуудад цэргийн албыг Ховдын Байтагийн заставт хаах хугацаанд хязгаарын цэрэгт туслах группийн олон гишүүд, тэр үед алба хааж байсан байсан офицерууд, ахмад хилчид, гадаадад тагнуулаар олон удаа ажиллаж байсан зарим хүмүүсийн яриа дурсамжуудыг сонсож билээ.

Гэтэл сүүлийн үед зарим ном хэвлэлүүд, сурвалжлагад зөрчилтэй зүйл нийтлэгдсэнийг уншаад худал үнэн аль ч болсон ирээдүйд түүхч, эрдэмтэн судлаачдад зориулж түүхийн үнэнийг судлаж тогтооход тус болох болов уу гэж бодож энэ сэдвийг бичив.

Монгол улсын баруун хязгаар нутаг, улсын хилийг Хятадын Гоманданы эзлэн түрэмгийлэгчид, Шинжааны Осван тэргүүтэй хасгийн дээрэмчид эх орноосоо урвасан зарим этгээдийг ашиглан, тэднийг зэвсэглэн турхирч, тагнан турших, хорлон сүйтгэх, ард иргэдийг алан хядах, эд хөрөнгө, мал сүргийг нь булаан дээрэмдэх, зарим иргэдийг хүчээр айлган сүрдүүлж, эх орноос нь урвуулах ажиллагааг 1929 оны сүүлээс 1950 оны эх хүртэл тасралтгүй явуулжээ. Тэд Монголын Баруун хязгаараас газар нутаг таслан авч, цаашид өөрсдийн үйл ажиллагааг явуулах байлдааны түшиц газар болгох зорилгыг агуулж байсан тул манай улсаас тухай бүрд нь тодорхой арга хэмжээ авч, няцаалт цохилт өгч байсан нь Баруун хязгаарт болж байсан хэрэг явдлуудаас тодорхой байдаг.

Баруун хязгаар дахь хэрэг явдал нь олон жил иргэлжилсэн шалтгаан нь:

- Сталин болон Коминтерний хятадад хувьсгал экспортлох гэсэн бодлого, үйл ажиллагааны хор уршиг ч нөлөөлсөн байж болох юм. Жишээ нь Монгол-Зөвлөлтийн тагнуулчдын үйл ажиллагааны үр дүнд хятадын Шинжаан–Уйгурт бие даасан Зүүн Туркестан улс тусгаар тогтнолоо 1948 онд зарлаж байжээ. 1951 онд хятадын хувьсгалын 3 жилийн ойн баярт оролцохоор нам, төрийн удирдагчид нь онгоцоор явж байгаад дэлбэрч сүйдсэн гэдэг.
- МАХН-ын 8 дугаар Их хурал Коминтерний төлөөлөгч Кучумов Черномордюгийн шаардлага, шахалтаар онол, арга зүйн ноцтой алдаатай шийдвэр гаргаж, Сталиний арга барил хэрэглэх, Коминтерний чиглүүлэлтээр Зүүн, Баруунтныг дайсанд тооцож, хар шар феодалын хөрөнгийг хураах, улс төрийн эрхийг хязгаарлах, шашны ёс журмыг дайран довтолж, сүм хийд, жасын хөрөнгийг хүчээр хурааж, устгах, баривчлан хорьж, шоронд ял эдлүүлэх зэрэг үйл ажиллагааг хүчээр явуулсан нь баруун хязгаарын ард түмний сэтгэл зүйд нөлөөлж, Төгс Буянт, Улаангом, Бодончийн хүрээний лам нарын бослого гарч, захчин, урианхай, торгууд, хасаг олон айл өрхүүд одоогийн хятадын Шинжаан-Уйгурын Алтай, Бор тал аймгуудын нутаг Чингэл, Цагаан тал, Эрчис, Шар сүм, Цонжийн нутгуудад 1930 оны эхээр дүрвэжээ. Жишээ нь, Ховдын Алтай, Үенч сумын 228 захчин өрх, Булганы 300 орчим торгууд өрх, Урианхайн 1106 рөх айлууд дүрвэж одоогийн Мөнххайрхан, Дуут сумын нутагт цөөн тооны урианхайчууд үлдэж, Алтай нутаг эзгүйрч, хасгууд орж ирж нутаглах болжээ.
- Монголын Богд хаант төрийн үед 10 гаруй хасаг айл Алтай нутагт ирж, газар гуйн амьдрах зөвшөөрөл авч байсан бол 1931 оны 12 дугаар сард хаятадын дотоодын байлдаан, үймээний хөлөөс зугатан 400 гаруй хасаг өрх айл орж ирснийг Засгийн газрын тусгай тогтоолоор оруулж, МАХН-ын Төв хороо, Чандмань Уул /Ховд/ аймгийн намын хорооны тогтоолоор тэднийг

Алтайн баруун хязгаарт болсон байлдаан,

зэвсэгт мөргөлдөөний тухай

Би зохиолч, түүхч, судлаач, сэтгүүлч биш боловч 1964-1967 онуудад цэргийн албыг Ховдын Байтагийн заставт хаах хугацаанд хязгаарын цэрэгт туслах группийн олон гишүүд, тэр үед алба хааж байсан байсан офицерууд, ахмад хилчид, гадаадад тагнуулаар олон удаа ажиллаж байсан зарим хүмүүсийн яриа дурсамжуудыг сонсож билээ.

Гэтэл сүүлийн үед зарим ном хэвлэлүүд, сурвалжлагад зөрчилтэй зүйл нийтлэгдсэнийг уншаад худал үнэн аль ч болсон ирээдүйд түүхч, эрдэмтэн судлаачдад зориулж түүхийн үнэнийг судлаж тогтооход тус болох болов уу гэж бодож энэ сэдвийг бичив.

Монгол улсын баруун хязгаар нутаг, улсын хилийг Хятадын Гоманданы эзлэн түрэмгийлэгчид, Шинжааны Осван тэргүүтэй хасгийн дээрэмчид эх орноосоо урвасан зарим этгээдийг ашиглан, тэднийг зэвсэглэн турхирч, тагнан турших, хорлон сүйтгэх, ард иргэдийг алан хядах, эд хөрөнгө, мал сүргийг нь булаан дээрэмдэх, зарим иргэдийг хүчээр айлган сүрдүүлж, эх орноос нь урвуулах ажиллагааг 1929 оны сүүлээс 1950 оны эх хүртэл тасралтгүй явуулжээ. Тэд Монголын Баруун хязгаараас газар нутаг таслан авч, цаашид өөрсдийн үйл ажиллагааг явуулах байлдааны түшиц газар болгох зорилгыг агуулж байсан тул манай улсаас тухай бүрд нь тодорхой арга хэмжээ авч, няцаалт цохилт өгч байсан нь Баруун хязгаарт болж байсан хэрэг явдлуудаас тодорхой байдаг.

Баруун хязгаар дахь хэрэг явдал нь олон жил иргэлжилсэн шалтгаан нь:

Сталин болон Коминтерний хятадад хувьсгал экспортлох гэсэн бодлого, үйл

ажиллагааны хор уршиг ч нөлөөлсөн байж болох юм. Жишээ нь Монгол-Зөвлөлтийн тагнуулчдын үйл ажиллагааны үр дүнд хятадын Шинжаан–Уйгурт бие даасан Зүүн Туркестан улс тусгаар тогтнолоо 1948 онд зарлаж байжээ. 1951 онд хятадын хувьсгалын 3 жилийн ойн баярт оролцохоор нам, төрийн удирдагчид нь онгоцоор явж байгаад дэлбэрч сүйдсэн гэдэг.

МАХН-ын 8 дугаар Их хурал Коминтерний төлөөлөгч Кучумов Черномордюгийн шаардлага, шахалтаар онол, арга зүйн ноцтой алдаатай шийдвэр гаргаж, Сталиний арга барил хэрэглэх, Коминтерний чиглүүлэлтээр Зүүн, Баруунтныг дайсанд тооцож, хар шар феодалын хөрөнгийг хураах, улс төрийн эрхийг хязгаарлах, шашны èс журмыг дайран довтолж, сүм хийд, жасын хөрөнгийг хүчээр хурааж, устгах, баривчлан хорьж, шоронд ял эдлүүлэх зэрэг үйл ажиллагааг хүчээр явуулсан нь баруун хязгаарын ард түмний сэтгэл зүйд нөлөөлж, Төгс Буянт, Улаангом, Бодончийн хүрээний лам нарын бослого гарч, захчин, урианхай, торгууд, хасаг олон айл өрхүүд одоогийн хятадын Шинжаан-Уйгурын Алтай, Бор тал аймгуудын нутаг Чингэл, Цагаан тал, Эрчис, Шар сүм, Цонжийн нутгуудад 1930 оны эхээр дүрвэжээ. Жишээ нь, Ховдын Алтай, Үенч сумын 228 захчин өрх, Булганы 300 орчим торгууд өрх, Урианхайн 1106 рөх айлууд дүрвэж одоогийн Мөнххайрхан, Дуут сумын нутагт цөөн тооны урианхайчууд үлдэж, Алтай нутаг эзгүйрч, хасгууд орж ирж нутаглах болжээ.

Монголын Богд хаант төрийн үед 10 гаруй хасаг айл Алтай нутагт ирж, газар гуйн амьдрах зөвшөөрөл авч байсан бол 1931 оны 12 дугаар сард хаятадын дотоодын байлдаан, үймээний хөлөөс зугатан 400 гаруй хасаг өрх айл орж

ирснийг Засгийн газрын тусгай тогтоолоор оруулж, МАХН-ын Төв хороо, Чандмань Уул /Ховд/ аймгийн намын хорооны тогтоолоор тэднийг

1

ухамсарлуулан сэнхэрүүлэх ажил зохиож, газар нутаг заан суурьшуулах зэрэг арга хэмжээ авч байжээ. Хасаг өрхүүд тасралтгүй олноор үргэлжилж орж байсан боловч тэд удалгүй 2430 хасаг өрх айл дүрвэн хил давжээ. Энэ нөхцөл байдлууд ч Баруун хязгаарын хэрэг явдлуудад ч нөлөөлжээ.

Манжийн хааны зарлигаар Халхын ван Цэрэн, Зүүн гарын хаан, Өөлдийн тайш Галданцэрэн нар “Ховдын хязгаарын нутаг дэвсгэрийн баруун хилийг Байтаг, Хавтагийн чиглэлд орших Огчин тооройн овоо, Байтагийн цаадах Хөвс ус, Наран мандах уул, Улаан боомын оройгоор Өрөнгө голд орж уруудан /хятадууд Үлэнгэр ч гэж нэрлэдэг/ Өрөнгө нуурт хүрч, баруун хойд зүг барьж, Нарийн хар уулаар дамжин, Эрчис голд орж уруудан явсаар Алагбиг голоор зүүн хойш чиглэн Их алтайн нуруугаар байхаар хилийн хэлэлцээр 15 жил үргэлжилж, 1737 онд тогтоожээ”1. “Монголын ноѐдод тулган хүлээлгэсэн Монгол, Орос, Хятад 3 улсын 1915 оны Хиагтын гэрээгээр Ховдын хязгаарын 10 хошууг /урианхайн зарим хошуу, торгуудын 2 хошуу, хошуудын 1 хошуу/ таслан авч хятадын Шинжаан мужид нийлүүлэхээр тогтжээ”2. Торгуудын ван Сэрээнэнгийн хүсэлтээр Манжийн хааны 1782 оны зарлигаар торгуудын 2 хошуунд Байтаг уул орчмын олгосон газрыг Гоминданы хятадууд манай газар нутаг гэж хууль эрх зүйн үндэслэлгүй маргаан үүсгэдэг байжээ. Монголын тусгаар тогтнолыг 25 жил хүлээн зөвшөөрөхгүй байсан Хятадын Гоминданы Засгийн газрын энэ маргаан нь юу ч биш юм. Гэтэл тэр үед хууль эрх зүйн үндэслэлээ гаргаж сайн

няцаалт өгч чаддаггүй, газар нутаг түүхэн хилээ сайн судлаж чадаагүй байсан бололтой юм. Ингэж нутгийн захиргааг хятадын Шар сүмд төвлөрүүлсэн нь хязгаар нутгийн ард иргэд хил давж нүүх нөхцлийг бүрдүүлжээ.

Богд Хаант Монгол Улс, Ардын хувьсгал ялснаас ч хойш тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Алтайн нурууны цаад газар нутгаа чөлөөлж, хилээ хамгаалж авч чадаагүй байдал ч хятадуудад бололцоо олгожээ. Ингэж Алтайн нурууны цаад түүхэн хилийн газар нутгийг Гоминданы хятадууд хүчээр эзэмшсэн нь Монголын баруун хязгаарт олон жил үргэлжилсэн зэвсэгт бослого, зэвсэгт тэмцэл болон хувирч байжээ. Тэр үеийн томоохон байлдаан, зэвсэгт тэмцлийн зарим нэг хэрэг явдлуудаас дурдвал:

1. Байтаг уулын Хужиртын эхний Ац Улаан /Команд/ ууланд болсон тулалдаан.

1947 оны эхээр Хятадын Гоминдан Ма Пу Гианы захирсан 10000 орчим хүний бүрэлдэхүүнтэй цэргийн анги Хужиртын эхний Ац улаан ууланд ирж хориглолт байгуулан байрлажээ. Хориглолтод шаардлагатай модон материалыг цэргүүд нь нэг эгнээ жагсаалаар зогсож, гар дамжуулан Байтаг уулнаас зөөжээ. Цэргийн агтанд улаан буурал, цагаан зүсмийн морьд ихэнх байжээ.

1972 оны Э.Гэрэлчулууны “Баатарлаг үйлстэн” номонд Нарийн хоргойтын өмнөх нэргүй өндөрлөгт гоминданы энэ цэргийн байрлалыг хянаж байсан харуул дайсанд илэрч нэгийгээ алуулсан тухай мэдээ авлаа гэж дурджээ. Харуулын ахлагч офицер нь дайсан хөөхөд нэг цэрэг нь алагдлаа гэж ирсэн нь сүүлд тагнуулын олзны Хуйхуй цэргийн мэдүүлгээр худлаа болох нь тогтоогджээ.

Энэ үед Монголын цэргийн хүч Байтагийн наана Уушгийн ус гэдэг газар төвлөрч, дайсныг дархан хилээс хөөж гаргахаар шийдвэрлэж, Дотоод Явдлын

Яамны сайд Шагдаржав удирджээ.

Дайсны хүн хүч, зэвсгийн хүч чадлыг урьдчилан мэдэх зорилгоор Нэхийтээр /улсын баатар/ даргалуулсан бүрэлдэхүүнд хилчин Тэгшээ /улсын баатар/, хасаг толгой буюу хүндэт байлдагч Дүгэр нар оролцсон 5-6 хүнтэй группийг явуулжээ.

2

Тагнуулын групп дайсны байрлалын ард зэрэгцээ нэргүй өндөрлөгт нууцаар байрлаж, цэргийн ангийн байрлалаас гадагш явах хүнийг баривчлахаар отолт хийжээ. Гэтэл бөмбөр, бүрээ дуугараад цэргүүджагсаалын сургууль хийгээд нэг ч хүн гадагш явалгүй өдрийн 10-11 цаг хүрч байтал дайсны нутгийн гүнээс 2 морьтой хүн ирж явааг хараад тэднийг баривчлахаар шийдвэрлэжээ.

Нэхийт хилчин пулемѐтчин Тэгшээг эндээ үлдэж бидний араас нэг ч дайсныг давшуулахгүй хамгаалах, морио сайн бөхлөж уях, туслах наводчик Даваадоржид дайсны нэг цэргийг буудах, нэг хилчинд дайсны нэг морийг буудах, хасаг толгой Дүгэрийнг замын хажууд нуугдаж морийг нь буудсан хүнийг амьдаар барих тушаалыг тус тус өгчээ.

Дайсны морьтой 2 хүн Дүгэрийн нуугдсан том чулууны хажууд ирэхэд хоѐр буун дуу зэрэг гарч морь нь буудуулсан хуйхуй цэрэг доош хараад гараараа газар даран унахад нь Дүгэр гүйж очоод нуруун дээр нь гишгэтэл эрүүгээрээ газар цохиод толгойгоо өндийлгөхөд нь уутаа толгойд нь углажээ. Нэг нь хуйхуй цэрэг, нөгөө нь хасаг хүн байжээ. Хуйхуй цэргийг моринд мордуулаад хөлийг нь хүлээд явах гэтэл алагдсан хасаг монгол цэргийн шинель өмссөн байсныг илтгэхэд Нэхийт авах тушаал өгчээ. Энэ үед Тэгшээ гүйж ирээд Нэхийтэд дайсан нааш давшсангүй, бүслэх зорилгоор 2 талаар давшлаа гэхэд бидний араас ир гэж тушаагаад Байтаг уулын Ар Хув гэдэг газрыг зүглэн гүн рүү зугатааж, Байтаг уулаа цаагуур нь бүтэн

тойроод урд үзүүрээр Тэрэм хадны урдуур гарч Оройхон Дамчигийн суман дээр дайсны хуйхуй цэрэг, 2 богцтой шуудан, монгол цэргийн шинелийн олзтой иржээ. Олзлогдсон хуйхуй цэргийн мэдүүлгээр – Гоминданы цэргийн анги 10000 орчим хүнтэй, миномѐт, хөнгөн пулемѐт, винтовоор зэвсэглэсэн, Ма Пу Гиан гэгчээр удирдуулсан, байнга суурьших зорилгоор орж ирсэн цэргийн анги болох нь тогтоогджээ.

Тэр үед цэргийн овог нэрийг цаасанд бичүүлж шинелийн заханд нууцлан хадуулдаг байсан нь Нарийн Харгайтын харуулд байгаад алагдсан гэх цэргийн шинель байжээ. Тэд дайсанд хөөгдөх үед дайсны суманд морь нь алагдахад сум хэрэгслээ үлдээж нөхрөө хаяад зугатсан учир үлдсэн цэрэг дайсантай баатарлагаар тулалдаж нас барьжээ. Ийм учраас Ма Пу Гиан жанжин монголын цэргийг амьдаар битгий барь, газар дээр нь устгаж байх тушаал гаргасан гэнэ.

Нарийн Харгайтын энэ харуулын дарга нь ЗХУ-д цэргийн сургууль төгссөн сайхан залуу байсан юм. Уушгийн усны толгод дунд дөрвөлжин чулуун гортгийг ахлагч Чирдэгжав бид нарт зааж, цэргийн хээрийн шүүх энд буудсан юм гэж Дүгэр гуай зааж билээ.

Манай цэргийн командлал Ма Пу Гианы цэргийн ангийг 3 хоногийг дотор Монголын хилээс гарах тулган шаардах бичгийг ард Бадам, Чулуундай нараар хүргүүлж, тэднийг Гэрэлчулуун даргатай, Нэхийт орлогчтой группээр хамгаалуулан явуулжээ. Тэд хоѐр элчээ явуулаад хүлээж байтал оройхон Чулуундай буцаж ирээд, дарга нь бололтой жороо бор морьтой хүн ирж бичгийг авлаа. Надыг явж даргаа авчир гэсэн би мордоод явсны дараа Бадам араас гоогоороо яв гэж хашгирсан гэж ярьжээ.

Тулган шаардах бичгийн хариуг өгөхгүй болохоор манай цэргийн байлдааны

ажиллагаа эхлэж давшжээ. Цэргийн давшилт эхлэх цагаас хоцорч, онгоц цагтаа бөмбөгдөж дайралт хийжээ. Манай цэргийг Хужиртын эхний Цалуу гэдэг цагаан газраар давшуулсан учир дайсны пулемѐт, миномѐтын гал толгой өндийлгөхгүй байжээ.

3

Үдээс хойш казакийн 200-300 хүний морин атак орж ирэхээр цэргийг Байтагийн наана ухраажээ. Нисгэгч Зайсанов дайсны суманд оногдсон онгоцыг өндөрлөг газраас гулсуулан Талын Хар уулын бэлд авч ирж буулгажээ.

Зайсанов нь буугаа гаргаж сумлаад командлагч ДЯЯ-ны сайд Шагдаржавын шанаанд тулгаж, чи яах гэж олон аавын хүүхдүүдэд команд өгч цусыг нь урсгав, чамайг хэний ч зөвшөөрөлгүй буудахад яадаг юм гэхэд Шагдаржав хасаг хүн ийм онгироо байдаг юм гэж зайлсхийж байсан гэдэг.

Ингэж цэргийг ухраахад Нэхийт /улсын баатар/-ын суман бартаат газраар давшсан тул дайсны байрлалд хамгийн ойрхон очсон байжээ. Гэнэт цэргүүд нь ухрахад нэг байлдагчийн хамт Нэхийт мориндоо хүрч чадалгүй нуугдаж хоцорчээ. Мөн суман нь ухрах үед хилчин Тэгшээгийн морь нь алагдахад гурван удаа морио тойрч гүйгээд, толгойг нь өргөж, Байтаг уулын оргил өөд харуулаад эмээлээ үүрээд жалга дагаад гүйгээд алга болжээ. Хэрэв дайсан Тэгшээг олзлох гэвэл шууд л буудахаас өөр арга байгаагүй гэж Нэхийт хожим хуучилж билээ.

Манай ухарсан сумангийн цэргүүд өндөр хадтай хонхорт орж, казакууд дээрээс нь өнгийж буудахад манайхан дороос нь буудаад нэлээд хугацаа өнгөрлөө. Нэг л гранат шидэхэд бүгд амиа алдах байлаа. Гэтэл нэг нь санаачлан доош дайралт хийж гарлаа. Яах ч аргаа олохгүй сандарч байлаа. Бид хоѐр илрэлгүй шөнө дайсны хүрээллээс гарч, анги дээр ирэхэд Нэхийт, Тэгшээ биднийг алагдсан гэсэн мэдээ төв

рүү явсан байж билээ. Байтагийн заставт 1965-66 онд сайдын шалгалтын комиссоор Нэхийт очихдоо, заставын дарга хошууч Цэдэв, орлогч дэслэгч Догсом, хасаг толгой буюу хүндэт хилчин Дүгэр нарын хамт явж, тэр үеийн нөхцөл байдлыг газар дээр нь танилцуулж байлаа.

Долоо хоногийн дараа цэргийг бартаат газраар давшуулж, хилээс дайсныг хөөж гаргасан юм.

Дайсны байрлалыг эзлэх үед халуун төмрөөр хөл, гарын булчин хүний зузаавтар махыг цоо цоо сэнжилж хайрсан түлэнхий шатсан хүний хүүр олдсон нь Бадам /баатар болсон/-ынх мөн гэж үзэж Уушигт авч ирж нутаглуулсан юм гэж хуучилж байлаа.

Хужиртын эхний Ац Улаан гэдэг өндөрлөг нь энэ үеэс “Команд”-ын өндөрлөг болж алдаршин нэрлэгдсэн юм.

1963 онд Монгол Хятадын хилийг тогтооход манай цэргийн анги байрлаж байсан түүхэн газар гэж хятадууд сар гаруй маргахад манай тал аргагүйн эрхэнд өгч, Командын өндөрлөгийн Хужиртын эхний Цалууд байсан Байтагийн хилийн застав дотогш хөөгдөж, Хужиртын голд иржээ.

2. Бүдүүн Харгайтын хилчин 10 баатрын тулалдаан.

Байтагийн Бүдүүн Харгайтын голын адгийн хойд талд байрласан дайсан 250-300 м өргөн фронтоор давшсан болов уу гэмээр хад чулуу ихтэй өндөрлөгт 1948 оны 7-р сарын 8-нд ихээхэн давуу хүчтэй дайсантай манай 10 хилчин тулалджээ. Дэмчигийн сумангийн улс төрийн орлогч Хаянхирваа: “Шуудхан хэлэхэд 50 гаруй жилийн өмнөх түүхэн баримт үйл явдлыг мушгин гуйвуулах гэсэн цэргийн тангараг нэгт Цэдэн-Иш генералт би туйлаас гомдсон шүү. Хойч үе маань үнэнийг дэнслэх болно”3… “Яг энэ үед морьдын байранд миномѐтын имна дэлбэрч

Дандархайдав шархдаж бид явгарцгаасан”4… “Архад маань миномѐт, гранат, пулемѐтын ширүүн галд өртөж амь үрэгдсэн юм”5… “Яг энэ үед манай нисэх онгоц ирж, бидний байсан өндөрлөг дээгүүр гурвантай тойрч, эргэлдэхэд дайсан сандарч

4

ухарсан юм”6 … гэжээ. “Ахлах дэслэгч Хаянхирваа ухарсан гэдэг нь огт худлаа, шууд хэлмэгдүүлэлт гэж үзнэ. Гүтгэлэг гэж хэлнэ. Цэдэн-Иш генерал дайнд ороогүй, албан тасалгаанд л байсан хүн шүү дээ. Хилийн цэргийн түүх архивыг үгүй хийхэд оролцсон хүн гэж боддог”7… “Буданчийн хөх толгойд нисэх онгоц байлаа. Нисэх онгоц хүрэхэд дайсан айж сандарч, ухарч зайлжээ”8… “Дандархайдав хоолойгоороо буудуулан бие нь хөөчихснийг харж…”9 … гэжээ.

Монгол улсын хөдөлмөрийн баатар, генерал Цэдэн-Иш манааны ахлагч Хаянхирваа нь маневрлан байлдах тактик хэрэглээгүй, 7 сарын 5-нд уг манааг дайсны 20-иод хүн ирж тагнаж байхад эсэргүүцэл үзүүлээгүй, манааны байрыг өөрчлөөгүй, Хаянхирваа, Гончигзэвэг, Чойжин нар ухарсан нь зөв боловч дайсны гол хүчний дайралтад байсан хилчин дайчдаа хамгаалах хэлбэрээр баруун талдаа ухралт хийгээгүй байсан, сумангийн дарга Майдраг, орлогч Хаянхирваа нар “ухарч үл болно” гэдэг тушаал өгсөн бол дайсанд барьж өгсөнтэй адил юм гээд энэ тулгаралтаас хилчин дайчдад зайлшгүй анхаарах шаардлагатай дүгнэлтүүдийг хийсэн байдаг.

Зөвхөн Байтагийн арван баатрын тухай биш хилийн манаа, застав, отрядын байлдааны үйл ажиллагаанд хойч үед сургамжтай, зайлшгүй анхаарах дүгнэлт хийсэн байдаг. Би олон удаа сонирхож уншиж байсан ба дуулж сонсож явсан зүйлүүдээс Хаянхирваа, Мягмаржав нарын ярилцлага нэлээд зөрүүтэй байдаг. Байтагийн заставын дарга хошууч Цэдэв, хасаг толгой буюу хүндэт хилчин

Батжаргалын Дүгэр /хүндэт байлдагч цолтой, сарын 60 төгрөгийн цалинтай, хилийн цэргийн бүх хангамжаар хангагдан амьдарч байсан/, Улсын баатар Нэхийт, ахмад хилчид, хязгаарын цэрэгт туслах группын зарим гишүүдийн хуучилж байсан одоо мартагдаагүй санаанд байгаа зүйлүүдийг дурдахад:

1948 оны 7 сарын 5-нд Бүдүүн Харгайтын постод дайсны цэргүүд 200-300 метрт ойртож, тагнан өдөөн хатгаж байгаад буцжээ. Энэ үед манай хилчид ажиглахаас өөр ямар ч арга хэмжээ аваагүй байжээ. Энэ байдалд дүгнэлт хийж сумангийн дарга ахмад Майдраг улс төрийн орлогч ахлах дэслэгч Хаянхирваагаар удирдуулан, хүч нэмэгдүүлж 7-р сарын 7-нд уг манааг гаргажээ. Хилчин байлдагч Дандархайдав нарын 3 байлдагч түлш бэлтгэж постынхонтой хамт байжээ. 7-р сарын 8-ны өглөө байрандаа пулемѐтчин Тэгшээ, хилчин Чойжин нарыг үлдээж, бусад нь өглөөний цай уухаар Бүдүүн Харгайтын гол дээр байжээ. Өглөө эрт 7 цагийн үед Бүдүүн Харгайтын гол дагаад болжмор жиргэж ниссэн тул ажиглахад газрын өнгөтэй адилхан ногооноор өнгөлөн далдалсан тэр хавийн газар хавтгайран хөдлөж байгаа юм шиг санагдахаар дайсан орж ирж буйг хараад Чойжин нөхдөө дууджээ. Дайсны тоог бүх хилчид тоолох гэж оролдсон боловч 150-300 хүртэл тоо гаргаж байсан гэдэг. Зөвхөн хилчин Тэгшээ 150 хүн байна гэж тодорхой тоог хэлсэн гэдэг.

Ахлах дэслэгч Хаянхирваа хилчин Пэлжээд мэдээ бичиж өгөөд сайн мориор явж холбоо барь гэжээ. Тэгэхэд хилчин байлдагч Тэгшээ миний хүрэн халзан мориор яв гэжээ /энэ морь Яргайтын заставын агтанд сэтэртэй байж байгаад 1960 оны сүүлээр үхсэн юм/. Хаянхирваа дарга өөрийн баруун гар талын өндөрлөгт Тэгшээ, Даваадорж, Гиваан нарыг, зүүн талын өндөрлөгт Чойнжин, Дандархайдав, Гончигзэвэг нарыг, өөрөө байлдагч Баянгийн хамт дунд нь хориглож, харин

байлдагч Архад /хасаг/-ыг хойд хонхортоо морьдоо бариулахаар томилжээ.
Дайсан ойртож ирсэн үед ахлах дэслэгч Хаянхирваа цагаан пуужин буудаж,
зогс гэж анхааруулахад дайсан давшиж эхлэжээ. Энэ үед манай хилчид ч хариу гал
нээжээ. Миномѐтын сум морьд байсан хойд хонхорт дэлбэрч, байлдагч Архад амь
үрэгдэж, морьд нь зугатаахад дайсанд уналга болгохгүйн тулд хилчид буудаж
5
устгажээ. Пулемѐтчин Тэгшээгийн дэргэд мина дэлбэрч, нэг хөл нь шөрмөсөндөө
тогтсон тул ахлах дэслэгч Хаянхирваа ухрах тушаал өгсөн боловч Тэгшээ ухраагүй.
Бага дарга Гиваан, наводчик Даваадорж нарч мөн ухраагүй гэдэг.
Байлдагч Баян, Дандархайдав нар 2-3 удаа буудаад, ан буудсан анчин шиг
өндийж харахад нь дайсан буудаж, амь эрсэджээ. Дандархайдав хоолойгоор
буудуулж, цогцос нь хөөсөн байсан нь хэт өндийсний нотолгоо юм.
Хаянхирваа нь Дандархайдав морь барьсан гэдэг нь худлаа юм. Тэд шинэ
дайчид байсан учраас гэнэдсэн гэдэг.
Дайсан хойд өндөрлөгийг тойрч байхад ахлах дэслэгч Хаянхирваа Бүдүүн
Харгайтын голын цаад өндөрлөгт Гончигзэвэг, Чойжин нарыг гаргаж хориглуулахдаа
дагаж хөөж амьдаар барих гэсэн дайснуудыг буудаад тэднийг хамгаалж чаджээ.
Гэтэл араас нь Хаянхирваа өөрөө гүйхэд дайснууд түүнийг амьдаар барьж авахаар
хөөхөд тэрээр Бүдүүн Харгайтын гол дагаад доош зугатаахад хориглосон хоѐр
байлдагчийн сум нь дуусан учир яаж ч чадаагүй гэдэг. Хаянхирваа гранат
дэлбэлэхэд бэлэн болгон гартаа бариад зугатаажээ. Энэ үед зэргэлдээ байсан
манааны цэргүүд буун дуу сонсоод туслахаар ирж яваа барааг хараад дайсан
зугатаажээ. Хилийн шугам ойрхон байжээ. Манаанд туслахаар ирсэн цэргүүд
дайсны барааг хараад хил давуулсан гэдэг. Хэрэв дайсан сумаа дуусгаагүй бол

Хаянхирвааг буудчихаад явах байсан байх.

Пулемѐтчин Тэгшээ сумаа дуусгаад пулемѐтоо эд ангиар нь задлаж, шидээд гол төмрөөр нь хад цохиж гулзаалгахад халуун улайссан гол төмөрт нь хоѐр гарын алганы арьс наалдсан байжээ. Гранатаа өөрийн цээжин доороо хийж дэлбэлжээ. Туслах наводчик Даваадорж МХЗЭ-ийн батлахаа чулуун доор хийж нуугаад гранатаа дэлбэлсэн кольцо нь гартаа байжээ. Бие зөвхөн нурууныхаа ясанд тасралгүй тогтсон байжээ.

Тасгийн дарга Гиваан МХЗЭ-ийн батлахыг урьж устгасан ба гранатаа нэг гартаа бариад гал хамгаалагчийг нь нөгөө гартаа атгасан байжээ.

Тэгшээ, Даваадорж нар өөрсдөө гранат дэлбэлж, амьдаар барих гэсэн дайсныг устгаж, шархдуулсан тул дайсан Гивааныг гранат шидэж устгасан гэж дүгнэлт хийж болохоор байжээ.

Тулалдаан өглөөний 8 цаг орчмоос 10 хүртэл маш ширүүн болж хоѐр талын сум хэрэгсэл нь дуусчээ. Зөвхөн гурван баатрын хориглосон өндөрлөгт 15 метр.кв орчим талбайд 16 миномѐтын сум дэлбэрсэн байжээ.

Сумангийн нэмэгдэл хүч өдрийн 14 цагийн үед очиход Хаянхирваа, Чойжин, Гочигзэвэг нар Бүдүүн Харгайтын голын эрэг дээр уйлсан сууж байжээ. Сумангийн нэмэгдэл хүч хамгаалж хоноод маргааш өглөө нь отрядын дарга дэд хурандаа Зоноровоор ахлуусан комисс ирж, нарийн шалгалт хийж акт бичжээ. Комисс дайсны зэвсэглэлийн хүчийг нэг чиглэлд давхардуулахгүй буудсан сумны хонгиог тоолон тогтоож, 50-60 газарт цус байсан ба 10 гаруй газарт их хэмжээгээр цус гаргасан мөр байсан нь ийм их хэмжээгээр цус алдсан хүн үхсэн байх гэж бодогдохоор байжээ. Дайсан нэг ч хүний хүүр үлдээгээгүй ба байлдаан болж байхад шархадсан, үхсэн хүнийг зөөж байгаа нь тодорхой харагдаж байжээ. Энэ нь дайсан ихээхэн хүн

хүчтэйг гэрчилж байгаа юм.

1949 онд төр засаг тэдний гавьяаг өндөр үнэлж, хоѐр хүнийг “Улсын баатар”, бусдыг “Байлдааны гавьяаны улаан туг”-ийн одонгоор, Пэлжээг “Байлдааны медаль”-аар шагнажээ.

6

Хаянхирваа нь У.Амарсайханы сурвалжлагад 3 хөдөлмөрийн баатар зэрэг олон алдартныг төрүүлсэн гэжээ. Хаянхирваа нь байлдааны талбарт торгон хил дээр “Улсын баатар”, эх орны бүтээн босгох үйлст гурван хөдөлмөрийн баатар болон олон алдартныг төрүүлсэн ахмад хилчин офицер, нам, цэргийн авьяаслаг удирдах ажилтан байжээ. Хаянхирваад “Эх оронч” цол олгосон бөгөөд хилчид эх оронч, алдарт хилчин гэж алдаршуулан хүндэлдэг юм.

Заставын дарга, хошууч Д.Цэдэв, хүндэт байлдагч Б.Дүгэрийн хамт 10 баатрын байлдсан Бүдүүн Харгайтын өндөрлөгт 2 удаа очиж, нөхцөл байдлыг яриулж, сонсоод, ингэсэн бол тэд амьд гарах байжээ, тэд ингэхгүй яасан юм бол гэж харамсах сэтгэл өөрийн эрхгүй төрдөг юм. Тухайн үед ямар хүнд нөхцөлд байсан, байлдааны явцад хэрхэн өөрчлөгдөж байсныг хэн ч мэдэхгүй шүү дээ. Иймд тэднийг одоо шүүмжлэн дүгнэх шаардлагагүй юм. Тухайн үед Хаянхирваа нь 3 баатрыг ухрах тушаал өгсөн боловч ухраагүй, хоѐр дайчнаа ухруулж, гурвуулаа амьд гарсан нь үнэлж баршгүй гавьяа гэж би үнэлдэг юм.

1970-1971 оны үед “Залуучуудын үнэн” ба “Намын үнэн” сонины аль нэгэнд отрядын дарга дэд хурандаа Зоноров даргатай комиссийн акт нийтлэгдсэн байсныг уншиж байснаа санахад Цэдэв, Дүгэрийн дурсамжуудтай адилхан байсан шиг одоо надад санагдах юм. Генерал Цэдэн-Иш гуай акт нь олддоггүй юм гэж бичсэн нь энэ үед гадагш гараад алга болсон юм болов уу гэж бодох юм.

Бүдүүн Харгайтын чиглэлээр хятадын гоминданы командлал 200-500 хүний бүрэлдэхүүнтэйгээр манай хилчдээс амьд хэл олзлох, манааг устгах зорилгоор 1947-1948 онд олон удаа дайралт хийж байжээ. Тухайлбал, 1947 оны 7-р сарын 4-нд Бүдүүн Харгайтын голд дайсны 300 хүн манааг бүслэхэд отрядын дарга дэд хурандаа Зоноров туслахаар очоод 6 хилчнээ алдаж, 3 хилчнээ шархдуулжээ. Мөн сарын дараа дайсны 500-аад хүний бүслэлтэд орж, байлдагч Чойжилжаваа 6-7 удаа шархдуулан бүслэлтийг дайрч, тухайн үеийн нөхцлийг сайн ашиглан гарч байсан гэдэг. 1948 оны 11-р сарын 2-нд бас л 300-аад хүний хүчээр өдөөн хатгалга хийж байжээ.

3. Осваны 22 баатар гэгчийг мөрдсөн ба Мэргэн ууланд болсон тулалдаан

1948 оны 5-р сарын 29-ний шөнө Бага Хавтагаар гоминданы хятадын зүгээс олон морьтон улсын хилийг зөрчиж, манай нутгийн гүн тийш явсныг 8-р заставын жагсаалын дарга Магсар илрүүлжээ. Хил зөрчигчид Ховдын Булган сумын Цоохор нуурт ирээд, ногооны тэмээ эрж явсан торгууд өвгөнийг баривчилж, даалгавраа биелүүлэх боломж, нөхцлийн талаар айлган сүрдүүлж мэдээлэл олж авчээ.

Тэд Хязгаарын цэрэгт туслах групын гишүүн хоршоо Дүгэр, Амарзаяа, хасаг толгой Дүгэр, багийн дарга Гэцэл болон офицер хилчдээс амьд хил олзлох даалгавар Осванаас авчээ. Энэ 22 баатар гэгчийн дунд манай тагнуулч Сагадай гэгч хасаг хүн хамт явж байгаад цоохор нуур орчмоос та нар явж бай би бие засаад араас чинь очьѐ гэж хэлээд хоцорч Булган сумын төвд ирж төлөөлөгч Гэрэлчулуунд мэдэгджээ. Энэ үедээ Сагаадай нь даалгавраа биелүүлээд буцаж ирэх шийдвэр төвөөс авсан байжээ.

Отряд яаралтай түгшүүр авч зохих арга хэмжээнүүдийг авч эхэлжээ. Амьд хил олзлох хүмүүсийн нэрсийн дотор багийн дарга Гэцэлийн нэр орсон учраас намын

товчооны дарга Чогров морин дивизионы төлөөлөгч Шагдаржав нарыг нэг цэргийн хамт явуулжээ. Чогров нар Гэцэлийнд очиход багийн дарга гэртээ байгаагүй учир араас нь яаралтай буцаж ир гэж хүнээр дуудуулжээ. Гэцэлийн эхнэр хоѐр офицерт архи гаргаж дайлжээ. Гэцэлийг шөнө буцаж ирэхэд хоѐр офицер согтуувтар байсан

7

тул хамгаалалтын арга хэмжээг өглөө авахаар шийдээд унтацгаажээ. Харин хамт явсан цэргээр морио аргамжиж мануулжээ. Шөнө дундаас хойш багийн дарга Гэцэлийг гэрээс гараад ирэхэд шилэнд нь цохиж унагаад гэрийн дээд бүсийг огтлон авч барьж хүлжээ. Казакууд морин дээрээс гэрийн баруун талаас доод бүслүүрээс нь өргөөд зүүн тийш нь шидэхэд зүүн талын орон дээр унтаж байсан эхнэр, хүүхэд нь гэр дотроо дарагдаж, баруун талд унтаж байсан хоѐр офицер гарч ирэхэд Чогровыг гэрийн доод бүсээр хүлээд тэд нарт хоѐр хүнээс илүүг олзлох шаардлага байгаагүй бололтой Шагдаржавыг шууд жадлаж эхэлжээ.

Гэцэлийн ах саахалт байсан тул шөнө нохой хуцаад олон хүний дуу гарахаар гараад хартал Гэцэлийн гадаа баахан хасгууд ярилцаж байгаа дуулджээ. Гэцэлийн ах гэрээсээ гурван ширхэг сумтай бярдан буугаа аваад морь манаж байсан цэрэг дээр ирж хоѐулаа бууджээ. Гэтэл цэргийн винтов нь гацаж дөрвөөс таван удаагаас илүү буудаж чадаагүй. Гэнэтийн буун дуугаар хасагууд Чогров, Шагдаржав хоѐрыг үлдээгээд Гэцэлийг хүлсэн гэрийн бүсний үзүүрээс дөрөөн доороо хийж давхихад гэрийн бүс тасарч Гэцэл хонхорт хоцорчээ. Чогров хүлээтэй буудаад бай буудаад бай гэж хашхирч байтал гэнэт буун дуу тасрахад бараан морьтой хасаг морин дээрээс Чогровийг шүүрч эмээл дээрээ хөндлөн тавиад давхиад явжээ. Чогровыг Мэргэн ууланд аваачиж моринд чиргүүлж зэрлэгээр тамлан алжээ. 6-р сарын 2-нд дайснууд Мэргэн ууланд байгааг онгоцоор эрэл хийж илрүүлсэн боловч уг онгоцыг

буудаж гэмтээснийг нисгэгч нар нь осолдолгүй буулгажээ. Мөн өдөр отрядийн эрлийн групууд Мэргэн уулыг бүслэн давшжээ. Энэ тулалдаанд офицер Халтмаа, Лхагвадорж /улсын баатар/, бага дарга, цэрэг 10 гаран хүн амь эрсдэж 5-6 хүн шархаджээ. Шарилыг Бодонгийн Хөх толгойд нутаглуулсан юм.

Дайснууд орой Мэргэн уулын хамгийн эгц, морьтой хүн бууж чадахгүй болов уу гэмээр газраар хасаг шовгор малгайн орой нь морины бөгсөнд наалдаад 10 хүн буугаад зугатаажээ. Орой болсон тул мөрдөж чадалгүй алджээ. Дайснаас 7 хүнийг алж, 3-ыг олзолж, нэг нь бууж өгчээ. 6-р сарын 7-8-ны үед одоо хятадын хилийн Нохойн хошууны заставын хажуу талын хар ууланд отолт хийж байсан хилчид 3 хүн очсны нэгийг нь буудаад хоѐрыг алдсан гэдэг. Бусад долоо нь Булган голын чиглэлээр Чингэл цагаан гол руу зугатаалган алджээ. Дайснууд шөнө учир хоорондоо баримжаа алдаж тасарсан бололтой. 1971 оны эхээр Ховдод “Хил дээр” кино гарч эхлэх үед тагнуулчаар Осваны дэргэд ажиллаж байсан Сагадай Ховд аймаг дахь НАХЯ-ны хэлтэс урилга өгвөл тэр киног би очиж үзнэ гэж ярьж байсан гэдэг. Иймд тасгийн дарга дэд хурандаа Шарав, төлөөлөгч Баяраа нар очиж кино үзэх урилга өгсөн шиг санагдаж байна.

4. Бага Хавтагийн Зээгийн усанд болсон хэрэг явдлын тухай

Байтаг, Их, Бага Хавтаг ууланд бүгэж байсан Осваны дээрэмчдийг устгахаар шийдвэрлэж манай цэргийн хүч одоогийн Алтай сумын нутаг Бор Цонжид төвлөрчээ. Цэргийг ДЯЯ-ны Хязгаарын цэргийг удирдах газрын дарга, улсын баатар, армийн генерал Б.Дорж командалж байжээ. Дээрэмчид хаана, ямар зэвсэгтэй, хичнээн хүн буйг урьчилан тагнаж мэдэх зорилгоор хасаг толгой Дүгэрийг тагнуулчаар сонгож явуулахаар болжээ. Батжаргалын Дүгэрийг тагнуулд гаргаж өгөрөөх 24 хүн бую Дүгэртэй хамт 25 хүний бүрэлдэхүүнтэй групп явжээ. Дүгэр гуай

хуучлан ярихдаа би хүн алаад Ховдын шоронгоос орголоо, зугатааж та нөхөд дээр ирлээ, надыг аварч үзээч, би та нарт үнэнчээр хүчин зүтгэнэ гэж ярьж, зэвсэглэл, хүн хүчийг мэдээд буцаж ирэх даалгавартай явжээ. Тагнуулын группийг Ховдын 5-р отрядын дарга Цэмбэл удирдаж, комиссар Балжинням штабын даргаар явжээ.

8

Бид Зээгийн усанд хүрэх замд хөнгөн пулемѐтыг хүртэл сумлаж бэлдээд, өндөр сонор сэрэмжтэй, байлдаанд бүрэн бэлэн байдалтай явсан юм. Дайсан Их Хавтаг уулын бэлд 50-100 гаруй хүн зээр хөөж байгаа харагдахад, энэ хүмүүст харагдахгүйг бодолцож, Бага Хавтаг уулаар халхавчлан Зээгийн усанд хүрлээ.

Энэ үед Ховдын Булган, Алтай, Үенч сумдын ардуудын морьдыг тооллогын картаар нь дайчлан татаж, цэргийг уналгаар хангасан юм. Нутгийн хамгийн хурпан морийг Цэнгэл дарга унаж явсан.

Биднийг Зээгийн усанд очиход отрядын дарга Цэмбэл намайг хоѐр сайн морь шилж унаад, Их Хавтагт буй дайсны дээрэмчид дээр очих, хэрэв групп илэрсэн бол надыг хөөж, мөрдөж яваа байх гэж ярьж, халхавлчах үүрэг өгөөд, би мордоод явахад Зээгийн усны орчим тэр тэр толгод дээр манааг гарга гэж үүрэг өгч байсан. Би хоѐр гүвээ даваад явж байтал ард буун дуу гарч, хоѐр хээр, хоѐр цагаан морьтой дөрвөн хасаг морин дээрээ гартаа буугаа барьж, надыг “тура тура тура тура” хасгаар “зогс” гэж хашгираад давхиж ирсэн. Би яах ч аргагүй боллоо. Их Хавтаг уулын урд нэлээд зайтай ”Аргал шандад” хилийн нууц манаа байв. Би үүргээ биелүүлээд тэр постон дээр очих ѐстой байлаа. Байтаг уулын бэлийн жижиг улаан уулыг чиглээд зугатаасан хасгууд надыг олон буудсан боловч оносонгүй. Нэлээд явсны дараа миний моринд дайсны сум тусч, товчлуураар цус олгойдоход хөтлөж явсан морио зэрэгцүүлэн ганзагатай богцоо шүүрч авахад морь минь газар шурган

уналаа. Дайснууд миний үхсэн морин дээр ирээд хоцорлоо. Би ч дээрэмчдээс холдлоо, орой ч боллоо. Шөнө Аргал шандын пост дээр ирэхэд нутгийн гүнээр Бор Цонжид машинаар надыг хүргэлээ. Отрядын дарга Цэмбэл шархтай зугатааж гарч ирсэн, 3 хоногийн дараа эмээлтэй бор морь гүйж иржээ. Иймд надыг нэг хүнтэй /Алтай сумын нэг цэрэг шиг санагдана/ Зээгийн усанд юу болсныг тагнуулахаар дахиж явуулсан юм.

Бид хоѐр Зээгийн усанд очиход их зэгстэй байсныг бүрэн шатаасан байсан ба 21 хүний шарилыг оллоо. Хасгууд манай хүмүүсийн бүх зэвсэг, хувцсыг бүрэн авсан байв. Балжинням, орчуулагч нарын цогцсыг олсонгүй. Дорж генерал цэргийн хүчээр Зээгийн усны орчим газрыг хамгаалалт хийж байгаад 21 хүний шарилыг авахад комиссар Балжинням нь хөнгөн пулемѐтоор 30 гаруй сум буудаад толгойдоо буудуулжнас баржээ. Осванууд үзээгүй учир зэвсэг, хувцсыг нь аваагүй байжээ. Орчуулагчийн цогцос олдоогүй учир түүнийг урвасан байх гэж сэжиглэж байлаа. Байтаг, Их, Бага Хавтагт байсан дээрэмчин хасгууд бүгд алга болжээ. 22 хүний цогцсыг Бор Цонжид авчирч нутаглуулсан юм.

Хожим олзлогдсон ба бусад хасгуудаас дуулахад орчуулагч Манжиев /зөвлөлтийн казах хүн/ дээрэмчид дайрах үед хувцсаа тайлж гараа өргөж би хасаг хүн байна, та нар надыг битгий алаач гэж хашгирахад Зээгийн усны ар толгой дээр том хадны хажууд, чулуун дээр сууж байсан осваны дөрвөн баатрын нэг гэгч этгээд над дээр явуул гэхэд хагас гарын 8 үсэрдэг буугаа гарынхаа алганд нуусан байсан тул дэргэд нь очоод баатрыг нь шууд буудан алж, дараа нь өөрийгөө бууджээ. Дараа нь олзлогсод ярихдаа дээрэмчид Баатар гэгчийгээ буудуулсанд өс хонзогнож Байтаг уулын ард үе мөчөөр нь салган тамлаж алсан гэжээ. Би хүндэт байлдагч Б.Дүгэрийг худал яриагүй гэж итгэдэг.

5. Улсын баатар хилчин Хорлоогийн Дамба

Ховдын хилийн 5-р отрядын 1-р сумангийн хянах пост нь Улсын хилээс 15 километрт Сагсайн голын зүүн талт 2706 тоот өндөрлөгт байрлаж байжээ.

9

1943 оны 7-р сарын 30-ны өдөр тасгийн дарга Намнангаар ахлуулсан байлдагч Дамба, Балжир, Лувсанпүрэв нар хилийн манаа нь үүрэг гүйцэтгэж байв. Энэ өдөр 100 орчим хүнтэй хасагийн дээрэмчид хил зөрчиж, манааг бүслэжээ. Хасагийн дээрэмчид манай хилчдэд сумантайгаа холбоо барих ямар ч боломж олголгүй холбоочин Балжирыг устгажээ. Манай гурван хилчин ашигтай байрлал эзлэхийн тулд 4 километр орчим газар ухран байлджээ. Лувсанпүрэв амь эрсдэж, дараа нь Намнан алагджээ. Дамба ашигтай байрлал эзлэж хүчээр түрж давшиж байсан дайсны эсэргүүцлийг амжилттай няцааж байжээ. Аргаа барсан дээрэмчид буцаад явахад Дамба тэднийг даллан дууджээ. Дамба энэ үед зөвхөн өөртөө зориулж нэг сум, гранат үлдээжээ. Дайснууд одоо л монголын цэргийн сум дууслаа, аргаа бараад бидэнд бууж өгөхөөр шийдвэрлэсэн байх, заавал амьдаар нь барь гэж хасгийн дээрэмчдийн ахлагч хорсож хонзогносондоо нөхддөө үүрэг өгчээ. Тэднийг ирэхэд Дамба граната шидэж ганц сумаа өөртөө зориулжээ. Дамба 7 удаа шархадсан байжээ. Олон жилийн дараа тагнуулын мэдээ болон энэ дээрмийн ажиллагаанд оролцож байсан хасгийн дээрэмчдийн олзлогдсон хүмүүсийн мэдүүлгээр 17 хүнийг устгаж, олон хүнийг шархдуулсан гэжээ. Дээрэмчдийн ахлагч монголын цэрэг шиг бүгдээрээ баатар эрс болъè гэж цуснаас нь амсаж, тангараг өргөж хасаг èсоор хүндэтгэн оршуулсан гэжээ. Энэ үндсэн дээр амь үрэгдсэн эх оронч цэргийнхээ алдар гавъяаг мэдэж, Дамбад 1961 онд “Улсын баатар” цол нэхэн шагнажээ.

6. Осваны баривчлах, устгах ажиллагааг хэрэгжүүлсэн нь

Осваныг баривчлах, устгах ажиллагааг 2 удаа авч хэрэгжүүлсэн боловч амжилт олоогүй.

Хоѐр дахь ажиллагааг 1948 оны 1-р сард явуулах үүргийг ДЯЯ-ны командлалаас дахин хязгаарын цэргийн командлалд өгчээ. Энэ үүргийг биелүүлэхийн тулд 1-р сарын тэсгим хүйтэн үед ардууд, цэргүүд оролцосн 300-аад хүний бүрэлдэхүүнийг хошууч Банзрагч даргалаж, орлогчоор нь Нэхийтийг томилон явуулжээ.

Осваны байрлалын орчимд тэмээгээр аргал түүж явсан эмэгтэйг баривчилж байцаахад тээр Осван гэртээ байгаа гэжээ. Иймд энэ эмэгтэйн мэдүүлгийг батлахын тулд тагнуул явуулжээ. Тагнуулаар авсан Халтмаагийн хэсэг 8 хүнийг баривчилж ирсэн ба Нэхийт, төлөөлөгч Ц.Уртнасан нар хасаг хувцас өмсөж яваад удалгүй онц чухал мэдээлэлтэй иржээ.

Олзны хүмүүсийн мэдүүлэг ба тагнуулчдын олж тогтоосноор Осван гэртээ хоѐр эхнэрийн хамт байгаа, хоѐр холбоочинтой, радио станц байрлуулсан, өдөр бүр гоминданы Шинжаанд буй цэргийн командлалтай холбоо барьдаг, винтов, хөнгөн ба хүнд пулемѐтоор зэвсэглэсэн, 300-аад цэрэгтэй үүнээс 200 хүн дээрэм хийхээр явсан, 100 цэрэг үлдсэнээс 30 нь байхгүй, одоо 70 хүн байгаа нь нотлогджээ. Иймд Осваны байрлалыг бүсэлж дайралт хийжээ.

Осван бага эхнэртэйгээ хоѐулаа 10-аад морьтны хамт бүслэлтийг дайрчээ.

Осван эхнэрийн хамт бүслэлтээс гарсны дараа ард Амарзаяа бага эхнэрийн морийг буудаж унагажээ. Эхнэр нь Осваны араас явган гүйхэд тэр эхнэрээ авахаар эргэж ирсэн болов авч чадалгүй зугатаажээ. Эхнэр нь хоѐр богц сум ганзагалж явжээ, өөр зүйл байгаагүй. Осваны араас мөрдөн хөөсөн боловч бидний морьд олон хоног

унаж явсан тул ядарснаас гүйцэж чадаагүй алдсан юм. Банзрагч, Нэхийт нар Осваныг хөөж яваад буцаж ирэхэд группд явсан ардууд Осваны гэрийн эд хогшлийг

10

бүгдийг нь хувьдаа авсан байсан тул Нэхийт маш их уурлаж, нэг хонхорт бүх эд хогшлийг хурааж, бүгдийг нь ачиж ирсэн юм.

Олзлогдсон, шархтай хүмүүсийг нэг хонхорт бөөгнүүлээд пулемѐтоор ширшиж устгасан юм. Өвлийн хүйтэнд шархтай хүмүүс бүгд л үхэх байсан байх, бидэнд устгахаас өөр арга байгаагүй. Манай талаас нэг ард, нэг цэрэг л шархадсан.

Осваны өмч хөрөнгөнөөс өгөөгүй учир тус группд явсан ардууд хонзогнож, Нэхийтийг дээш нь матсан учраас Баатар цол өгүүлэхгүй удааж, нэлээд хохироож, 1962 онд олгожээ.

Үүнээс өмнө хасгийн дээрэмчдэд маршал Дэмид жанжин цэргийн хүчээр цохилт өгч, дээрэмдсэн мал хөрөнгийг буцаан авчирж, Булган, Үенч, Алтай, Мөнххайрхан сумын ардуудад тараахад зарим айлын мал зүсээрээ ирж байжээ.

7. Олон булангийн сумангийн дарга, ахмад Майдрагийн алдарт хориглолт.

Олон булгийн суман нь Байтаг уулын өмнөд үзүүрт Сэнжийн хадны нуруунд хилийн хяналтын нууц манаа гаргадаг байжээ. 1950 оны 3-р сарын сүүлчээр хилчид манаанаас бууж ирэхдээ орой нар жаргахын үед Байтаг уулын урд үзүүрээр 800-аад морьтой цэргийн цуваа ирж байна, түүний хойноос маш их тоос гарч байна, байдлыг ажиглавал түүнээс 2 дахин их хүн хүч ирж яваа бололтой гэж мэдээлжээ.

Энэ үед суман дээр хилийн газрын зураг хийх ажлаар явсан орос цэргийн 3 офицертой тасаг шахам хүн байжээ. Сумангийн дарга ахмад Майдраг энэ мэдээг хүлээж аваад офицеруудын гэр бүл, хүүхдийг ногооны зооринд нууж, сумангийнхаа бүх бичиг баримтыг устгаж, хориглолтод орж, бэлтгэлээ хангаж байтал шөнийн 12

цаг өнгөрч байхад дайсны түрүүч нь ирж, шууд давшилтад оржээ. Шөнөжин пуужингийн гэрэлд байлджээ. өглөө үүр хаяарч, гэгээ ороход дайсан ухарчээ. Газарт гэгээ сайн орохоор харахад сумангийн байрлалын орчим толгойд дүүрэн улаан туг, дарцаг харагджээ.

Энэ шөнийн хориглолтын үед сум зөөж байсан нэг байлдагч амь эрсдэж, жагсаалын дарга Чулуунбаатар хүнд шархаджээ. Нөхцөл байдлыг ажиглаад ахмад Майдраг 2 цэрэгт цагаан туг бариулаад явуулахад мөн урдаас цагаан туг барьсан хүмүүс ирж уулзжээ. Шөнө дайрсан дайснууд маань Хятадын чөлөөлөх 3-р армийн анги, нэгтгэлүүд байжээ. Энэ шөнө Хятадын чөлөөлөх армийн цэргүүдээс нэлээд олон хүн алагдаж шархадсан ба хорооны дарга хүн хүртэл хүнд шархаджээ.

Осваны олзлогдсон нэг хасаг Осван хаана байгааг зааж өг гэхэд нь манай сумангийн байрлалыг Осваны байрлал гэж Хятадын чөлөөлөх армийнханд зааж өгснөөс болж манай суман, Хятадын чөлөөлөх армийн ангиудын хооронд мөргөлдөөн болжээ. Хятадын чөлөөлөх армийнхан тэр хасгийг хоѐр улсын цэргийн жагсаалын өмнө Олон булагт шууд буудан устгажэ. Түүнийг буудсан газар гэж дөрвөлжин, чулуун гортигыг ахмад хилчид зааж билээ.

Байтагийн урд үзүүрт Тэрэм хад гэж нар тусдаггүй байнга сүүдэртэй байдаг газар бий. Манай заставын хил эргэж явсан хилчид шархтаныг эмчилж байсан бололтой маш их цустай бололтой хүрэн өнгөтөй болсон эмнэлгийн боолтын марль байна гэж ярьж ирж байлаа.

Хятадын шархадсан цэргүүдийг эмчилж, эдгээгээд намар нь хоол хүнстэй, тэмээгээр хүргэж өгсөн юм гэж ахмад хилчид хуучилж ярьдаг.

Хошууч Майдраг нь Монгол-Хятадын хилийг 1963 онд тогтоохоос өмнө Байтагийн хилийн заставын даргаар ажиллаж байжээ. Би бол цэрэг хүн, эх орныхоо

хилийг цэрэг зэвсгийн хүчээр хамгаална, харин одоо хятадууд тайван замаар эзлээд

дууслаа гэж хэлээд Улаанбаатар хот яваад дахиж хил дээр буцаж ирээгүй ба оронд нь Цэдэв ирсэн гэж ярьдаг. Ахмад хилчид Майдрагийг магтан ярих дуртай, Олон булагийн хориглолтыг Майдрагийн алдарт хориглолт гэж хилчид хүндлэн нэрлэдэг юм. Хошууч Майдраг, ахлах дэслэгч Хаянхярваа нарт Улсын баатар цол нэхэн олгох нь зүйтэй болов уу гэж боддог юм.

Үүнээс гадна олон арван удаа хилийн зөрчил будлиануд гарч, олон дайчин хилчид амь эрсдэж, эх орны дархан хилийн шугамаа хамгаалсан олон үйл явдлууд бий. Мөн хилчин дайчдаас гадна хятадын нутгийн гүнд биечлэн тагнуул хийх, тагнуулын ажлыг амжилттай зохиож байсан Гэрэлчулуун, Царцайн Уотнасан, Ууш гэх мэт олон ажилтнууд, өөрийн хүч хөдөлмөрийг эх орныхоо аюулгүй байдлыг хангах үйлст зориулсан нууц фронтын дайчин “хасаг толгой” Дүгэр, Амарзаяа, Бүрэнтөгс зэрэг олон арван хүмүүс, болсон олон үйл явдлыг ахмад хилчид бахархан магтан ярьж явдаг билээ.

Зарим ном хэвлэлүүд, сурвалжлага тэмдэглэлүүдэд тагнуулын байгууллагын ахмад ажилтнууд, тагнуулчдын тухай дурдсан байгаа боловч тодорхой дурдаагүй, алдар гавъяаг дутуу дулимаг бичсэн байгаа нь цаашид мартагдаж болзошгүй тул тодорхой бичиж, дурдагдаагүй хүмүүс, үйл явдлуудыг тодорхойлон гаргах нь ирээдүйд залуу үеийг эх оронч үзэл санаагаар хүмүүжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Баруун хязгаарт олон жил үргэлжилсэн тэмцлийн явцад дайсанд сайн дурааараа олзлогдсон тагнуулын байгууллагын ажилтан, тагнуулчид, хилчид байгаагүй юм. Тэд өөсрдийн мэдлэг боловсрол, боломж нөхцөл, хүч чадлаа бүрэн

ашиглаж байсан боловч аргагүй хүч чадал, нөхцөл боломж хүрэхгүй байх, сонор сэрэмж алдах, гэнэдэх зэргээс болж хохирол хүлээж, амь насаараа эрсдэж байсан багагүй жишээнүүд дуулддаг.

Ахмад үеийн бидэнд хийж бүтээсэн зүйлийг тухайн үеийн төр засгийн бодлого, бодит нөхцөл байдлаар үнэлэн дүгнэж үзэхгүйгээр орчин үеийн техник, шинжлэх ухааны ололт, оюун санаа, ухамсарт гарсан их өөрчлөлтүүдийг харгалзахгүй, их мэдэгчийн дүрээр туйлшран шүүмжлэх, буруушаах нь гол биш юм.

Энэ нь дүгнэлтийг зөв хийж чадахгүй л болов уу.

Бидэнд олдсон эрх чөлөө, эх орны маань тусгаар тогтнол, хил хязгаарын бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг хангахад ахмад үе маань амар хялбар, шууд дардан замаар яваагүй нь ойлгомжтой юм. Иймд ахмад үеийн алдар гавьяаг судлан мөнхжүүлэх нь чухал юм.

Ашигласан ном зохиол:

1 1937 оны Халх-Єєлдийн хилийн гэрээ, Ховд хязгаарын нутгийн 1890 оны газрын зураг, тайлбарт тодорхой бий.

2 Хиагтын гэрээний 11-р зүйл, Илэрхийлэн гаргах бичгийн 4-р зүйл.

3 У.Амарсайхан. “Уулын бүргэд ч уйлдаг” ном. 1995 оны хэвлэл. “Арван баатрын шударга дарга Хаянхирваатай хийсэн сурвалжлага.

4 Мєн сурвалжлагад.

5 Мєн сурвалжлагад.

6 Мєн сурвалжлагад.

7 Мєн номын “Буданч /Бодонч/-ийн Хєх толгой хоѐр” сурвалжлагад.

8 Мєн сурвалжлагад.

9 Мєн сурвалжлагад.

Байнжуур овогтой Хорхон элэгний М.Гатав.

13